



МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМ

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,
Барилгачдын талбай 3, Засгийн газрын XII байр,
Утас: 31 06 12, 7600 3333-1126, Факс: (976-11) 32 29 04,
И-мэйл: info@mcud.gov.mn, Вэбсайт: www.mcud.gov.mn

2022.04.13 № 3/1613

танай _____-ны № _____-т

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАРТ


“Хэмнэлтийн горимоор ажиллуулах тухай”
Барилга, хот байгуулалтын сайдын 2022 оны 04 дүгээр
сарын 11-ний өдрийн 85 дугаар тушаалын хуулбарыг
хавсралтаар хүргүүлж байна.

Энэ тушаалын хэрэгжилтийг хангуулж,
биелэлтийн талаарх тайланг улирал тутам Барилга,
хот байгуулалтын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ,
дотоод аудитын газарт ирүүлж байхыг мэдэгдье.

Хавсралт: 1 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

С.МАГНАЙСҮРЭН



152261262



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 85

Улаанбаатар хот

Хэмнэлтийн горимоор ажиллуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, мөн зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн ээлжит бус хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барилга, хот байгуулалтын яамны удирдах албан тушаалтан, харьяа байгууллагын дарга, удирдах албан тушаалтан болон төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч нарыг 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн хөдөө орон нутагт албан томилолтоор ажиллахаас бусад тохиолдолд албан ажлын хэрэгцээнд туулах чадвар бүхий том оврын автомашин ашиглахыг хориглосугай.

2. Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас үүдэлтэй хил гаалийн хориг, бараа материалын үнийн өсөлтөөс шалтгаалан бий болоод байгаа эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг харгалзан цалин хөлс, татвар, даатгал, тэтгэвэр тэтгэмж, ашиглалтын үйл ажиллагаатай холбоотой цахилгаан, дулаан, усны төлбөрөөс бусад тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авах, сургалт, семинар, спорт, соёл урлагийн арга хэмжээ, баяр ёслол, тэмдэглэлт ойг зохион байгуулах зэрэг үндсэн үйл ажиллагаатай холбоогүй бүх зардлыг санхүүжүүлэхгүй байхад онцгойлон анхаарч, санхүү, эдийн засгийн хэмнэлтийг байгууллагын бүх шатанд гаргаж, хяналт тавьж ажиллах, хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайланг улирал бүр ирүүлэхийг төсвийн шууд захирагч, байгууллагын дарга, төслийн зохицуулагч нарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын 1, 2-т заасны дагуу авч хэрэгжүүлсэн ажлын тайланд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тухай бүр танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /О.Лхагвацэдэн/-т даалгасугай.

4. Энэхүү тушаалыг зөрчсөн удирдах болон гүйцэтгэх шатны бүх албан тушаалтанд захиргааны арга хэмжээг авч ажлаас чөлөөлөх хүртэлх хариуцлага тооцож ажиллахыг төсвийн шууд захирагч, байгууллагын дарга нарт даалгасугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангаж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэнд үүрэг болгосугай.

Б.МӨНХБААТАР

152210237